



БУЛГАН АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
..... ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2021 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 21/05

Булган

"Шинэ багш"  
хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-ын "ж", 19 дүгээр зүйлийн 19.1, Боловсролын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2, Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан "Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 2.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын найм дахь удаагийн сонгуулийн 2020 оны II хуралдааны II/04 дүгээр тогтоолоор батлагдсан "Булган аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны "Шинэ хөгжлийн зам" хөтөлбөр"-ийн 1.2.4.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Шинэ багш" хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.
2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын арга хэмжээг авч, биелэлтийн үр дүнг бүтэн жилээр тооцон, шаардагдах зардлыг жил бүрийн төсөвт тусган ажиллахыг аймгийн Засаг дарга /Б.Ариун-Эрдэнэ/-д үүрэг болгосугай.
3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /Д.Батчулуун/-д даалгасугай.

ДАРГА



Д.ЭРДЭНЭБАТ



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2021 оны 04 сарын 23 өдөр

Дугаар А/197

Булган

Төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 а, Боловсролын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.2, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны "Шинэ хөгжлийн зам" хөтөлбөрийн 1.2.1-ийн 2, 1.2.4-ийн 1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Шинэ багш" хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2021-2022 оны арга хэмжээний төлөвлөгөөг 1 дүгээр, "Шинэ ирээдүй" хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2021-2022 оны арга хэмжээний төлөвлөгөөг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах ажлыг нутаг дэвсгэрийн хэмжээнд шуурхай, чанартай зохион байгуулж ажиллахыг сумын Засаг дарга нарт, хэрэгжилтийн явцад хяналт, шинжилгээ үнэлгээ хийж, мэргэжил арга зүйгээр ханган, ажлын явц, үр дүнг жил бүрийн 11 дүгээр сарын 01-ний өдрийн дотор аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулахыг Боловсрол, соёл, урлагийн газар /Ж.Ганболд/-т үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, салбар дундын зохицуулалт, удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс /Д.Оюунбилэг/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
найм дахь удаагийн сонгуулийн III хуралдааны  
... дугаар тогтоолын хавсралт



## “ШИНЭ БАГШ” ХӨТӨЛБӨР

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Боловсролын салбарт бодит хувь нэмэр оруулах, өөрийгөө тасралтгүй хөгжүүлэх чадвартай, багшид ажлын байрандаа тогтвор суурьшилтай ажиллах орчин нөхцөлийг бүрдүүлэх нь боловсролын шинэчлэлийн нэн чухал асуудал билээ.

Багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийг дэмжих бодлогыг холбогдох хууль тогтоомж, эрх зүйн баримт бичгүүдэд тусган хэрэгжүүлж иржээ. Тухайлбал: “Багшийн хөгжлийг дэмжих тухай хууль (2018)”, “Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого (2014-2024)”-уудад багшийн хөгжлийг дэмжих тогтолцоо бүрдүүлэх, багшийн хөгжлийн хөтөлбөрийг батлуулан хэрэгжүүлэх, багшийн ажлын гүйцэтгэлд суурилсан урамшуулал олгох, хөдөлмөрийг бодитой үнэлэх тогтолцоо бүрдүүлэх асуудлыг тус тус тусгажээ.

Түүнчлэн Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа 2050”, “Боловсролын салбарын дунд хугацааны хөгжлийн төлөвлөгөө (2021-2030)”, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны “Шинэ хөгжлийн зам” хөтөлбөр (2021-2024), аймгийг хөгжүүлэх үндсэн чиглэл (2021-2025) зэрэг бодлогын баримт бичгүүдэд Боловсролын чанарыг сайжруулах тулгуур зорилтуудыг дэвшүүлсэн.

Тухайлбал суралцагчийн хөгжлийн хэрэгцээг хангасан, ур чадвартай бүтээлч багш нарыг бэлтгэх, тэднийг багш мэргэжлийн стандартад суурилсан тасралтгүй хөгжлийг хангах, дижитал технологи ашиглах зэрэг олон зорилт, үйл ажиллагааг тусган төлөвлөсөн байна.

Технологийн хурдацтай хөгжил, хөдөлмөрийн зах зээлийн хувьсал, хот, хөдөөгийн хөгжлийн ялгаа, онцлогоос үл шалтгаалан суралцагч нь шинжлэх ухааны мэдлэг, танин мэдэхүй, нийгэмшихүй, сэтгэл хөдлөлийн чадвартай, сониуч, өөрийн суралцахуйг удирддаг, бусдын санал бодол, үнэт зүйлд хүндэтгэлтэй ханддаг, өсөх сэтгэлгээтэй байх шаардлагатай болж байна.

Иймээс багш нар өөрсдөө мэргэжлийн мэдлэг, ур чадвартай байхаас гадна сурагчдын мэдлэг, чадвар, хандлагад гарах үр дүнд баримжаалан сургалтын хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлдэг, сургалтыг удирдан чиглүүлдэг мэргэшсэн чадамжтай (expertise), тасралтгүй хөгжих хандлагатай, технологийн ололт дэвшлийг ашигладаг, бусадтай хамтран багаар ажиллах чадвартай байх хэрэгтэй юм.

Энэ мэдлэг, чадвар, хандлагыг багш өөрөө, бие дааж хөгжүүлдэг байх нь хамгийн үр дүнтэй гэж үздэг бөгөөд төрийн зүгээс багш нар тасралтгүй хөгжих боломж, нөхцөлөөр хангах, багшийн ажлын үр дүнд суурилсан урамшууллын хөшүүргийг бодитоор дэмжих нь багшид чиглэсэн бодлогын тэргүүлэх зорилт болохыг олон улсын болон бусад аймаг, орон нутгийн туршлага, сурамж бэлхэнээ харуулж байна.

## ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Булган аймгийн хэмжээнд сургуулийн өмнөх боловсролын 22 байгууллагын 254 багш, 40 удирдах ажилтан, ерөнхий боловсролын 22 сургуульд 11124 суралцагч, 641 багш, 56 удирдах ажилтан ажиллаж байна.

Булган аймагт 2020 оны байдлаар багшийн чадамж, багшлахуй, суралцахуй болон сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, суралцагчдын ахиц амжилтад хийсэн судалгааны үр дүнгээс харахад: Багш нарын мэргэжлийн онолын мэдлэгийн түвшин 66 хувьтай, ЭЕШ-ын хэмжээст онооны дундаж 481, чанарын үнэлгээний судалгааны дундаж гүйцэтгэл бага боловсролд 45.0 хувь, суурь боловсролд 36.5 хувь, бүрэн дунд боловсролд 26.0 хувьтай байсан бол багш нарын арга зүй, сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хийсэн тоон болон чанарын үзүүлэлтээр сайжруулах шаардлагатай гэж тус тус үнэлэгдсэн байна.

Аймгийн хэмжээнд нийт ерөнхий боловсролын сургуулийн багш нарын 28.1 хувийг 30 хүртэлх насны, 33.5 хувийг 5 хүртэлх жилдээ ажиллаж буй залуучууд бүрдүүлж байгаа нь боловсролын салбарт эрч хүчтэй, шинэлэг сэтгэлгээтэй хойч үеийн залгамж халаа бэлтгэгдэж байна гэж үзэж болох хэдий ч нөгөө талаас тэднийг арга зүй, ур чадварын хувьд туршлагажуулахад ихээхэн анхаарах ёстой.

Түүнчлэн Монгол улсад багш бэлтгэх чиглэлээр 7 их дээд сургуулийн 31 хөтөлбөр нь магадлан итгэмжлэгдсэн байгаа нь багш бэлтгэдэг 46 их, дээд сургуулийн 15.2 хувийг эзэлж байна, нийтдээ багш бэлтгэх нэгдсэн хөтөлбөргүй гэж хэлж болохоор байна.

Багш бэлтгэдэг их, дээд сургуулиудын төгсөх ангийн 541 оюутныг хамруулан багш мэргэжлийн стандартын түвшинг тогтоож үзэхэд 16.8 хувийн амжилттай, 0.9 хувийн чанарын үзүүлэлттэй шалгагдсан байна.

Манай аймгийн хувьд ч шинэ төгсөгч багш нараас мэргэжлийн ур чадварыг үнэлэх зорилгоор "Батламж" шалгалт авдаг бөгөөд 2020-2021 оны хичээлийн жилд тус шалгалтад нийт 104 шинэ төгсөгч шалгуулснаас дундаж гүйцэтгэл 55.0 хувьтай байгаа нь шинэ төгсөгч багш нарын мэдлэг, хандлага, ур чадвар хангалтгүй байна гэж дүгнэж болохоор байна.

Сургалт, үйл ажиллагааны чанар, суралцагчдын сурлагын амжилт, хүмүүжил, төлөвшилд бодитой ахиц гаргахад багш голлох үүрэгтэй.

Багшийн мэргэжлээрээ тасралтгүй хөгжихтэй холбоотой хийгдсэн судалгаануудаас үзэхэд тэднийг төвлөрсөн байдлаар "хайрцагласан" сургалтаар хөгжүүлэх гэж оролдох нь үр дүн муутай гэдэг нь харагдаж байна.

Харин ажлын ачаалал, мэргэжлийн мэдлэг, чадварын түвшин, сургалтын онцлог, нас, хүйс, туршлага байршлаас үл хамааран бие даан хөгждөг, багшийн ажлын гүйцэтгэл, үр дүнд суурилсан цалин, хөлс, нэмэгдэл урамшуулал, нийгмийн баталгааг бодитоор шийдвэрлэдэг байх нь сургалтын чанараа илүү сэдэл тэмүүлэлтэйгээр тасралтгүй сайжруулах, суралцагчийн сурах, хөгжих үйл явцыг илүү таньж мэдэх, ахиц амжилт гаргах шийдэл, арга зүйг олж мэдэхэд бодитой дэмжлэг болдог байна.

Иймд багш нарыг хүүхэд төвтэй суралцахуйг дэмжсэн арга зүйн чадамжтай, тасралтгүй хөгжих хандлагатай, мэргэжлийн ур чадвар, мэдээлэл технологи, багаар ажиллах өндөр чадвартай багш нарыг хөгжүүлэхэд "ШИНЭ БАГШ" хөтөлбөрийн ач холбогдол оршино.

## **ХОЁР. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО,**

### ***Тэргүүн туршлага, ур чадвар, тасралтгүй хөгжил, үр дүнг дэмжих***

Багш өөрөө бие даан мэргэжлээрээ тасралтгүй хөгжих, багш ажилдаа сэтгэл хангалуун байх, ажил мэргэжилдээ дуртай байх, тогтвор суурьшилтай ажиллах, багшийн эрэлтийг хангахад тэдний ажлын байрны нөхцөл, цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, нийгмийн баталгаа зэрэг нь чухал хөшүүрэг болдог.

Багшийн ажлын нөхцөлтэй холбоотой өөр нэг чухал асуудал нь ажлын гүйцэтгэлийн үр дүнд суурилсан үнэлгээ, түүнийг цалин хөлс, урамшуулалтай уялдуулах явдал бөгөөд багш нарт мэргэжлээрээ тасралтгүй, уян хатан хэлбэрээр хөгжих боломж олгох онооны систем бүхий тусгайлсан журам, шалгуур үзүүлэлт, гүйцэтгэлийн үнэлгээнд суурилсан урамшуулах, хариуцлага тооцох системийг бий болгох явдал юм.

### ***Багш нарын тасралтгүй хөгжих орчин нөхцөлийг бүрдүүлэх***

Багш уян хатан хэлбэрээр мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагаа, сургалтад хамрагдахад мэдээлэл харилцаа, технологийн хэрэгсэлтэй, интернетийн орчин хангагдсан байх шаардлагатай.

Ялангуяа орон зай, цаг хугацаанаас үл хамааран онлайн, зайн сургалтын хэлбэрээр мэргэжлийн ур чадвараа сайжруулахад тэдэнд компьютер, сканер, принтер, канон гэх мэт сургалтын хэрэглэгдэхүүнтэй байх хэрэгтэй.

## **ГУРАВ. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛТ**

Хөтөлбөрийн зорилго, чиглэлийг хэрэгжүүлэх хүрээнд нийцүүлэн дараах зорилтуудыг дэвшүүлж байна. Үүнд:

- 3.1. Багш нарын мэргэжлийн чадамж, стандартад суурилсан тасралтгүй хөгжлийг дэмжих удирдлагын менежментийн чадавхыг бэхжүүлэх
- 3.2. Сургуулийн өмнөх болон бага, суурь, бүрэн дунд боловсролын чанарын үнэлгээнд суурилан багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийг мэргэжлийн ур чадвар, хандлагын судалгаанд үндэслэн хэрэгжүүлэх
- 3.3. Багшийн ажлын нөхцөл, тасралтгүй хөгжил, багш, ажилтны урамшуулал, нийгмийн баталгаа, сургалтын орчин, нөхцөлийг дэмжих
- 3.4. Боловсролын салбарын цахим шилжилтийг нэмэгдүүлж, цахим платформыг хөгжүүлэх замаар сургалтын үйл ажиллагааг дэмжих

## **ДӨРӨВ. ХӨТӨЛБӨРИЙН ЗАРЧИМ**

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг мөрдлөг болгоно. Үүнд:

- 4.1. Хөтөлбөрийн агуулга, хэрэгжилт нь нийгмийн хөгжил, орон нутгийн онцлог, хэрэгцээ шаардлагад нийцсэн уян хатан байх;
- 4.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь нээлттэй, хүртээмжтэй, тасралтгүй, тэгш байдлыг хангасан байх;
- 4.3. Сургууль, цэцэрлэгт суурилсан мэргэжлийн тасралтгүй хөгжилд тулгуурлан, багш, удирдах ажилтны манлайллыг хөгжүүлэх;

- 4.4. Багшийн мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагаанд технологийн дэвшил, цахим агуулгыг ашиглах;
- 4.5. Төр, хувийн хэвшил, төрийн бус байгууллага, эцэг эх олон нийтийн хамтын ажиллагаа, хариуцлагад тулгуурлах

#### **ТАВ. ХӨТӨЛБӨРИЙН ХУГАЦАА**

Хөтөлбөрийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулан 2021-2024 онд хэрэгжүүлнэ.

#### **ЗУРГАА. ХАМРАХ ХҮРЭЭ**

- 6.1. Цэцэрлэг, сургуулийн хүүхэд, суралцагсад
- 6.2. Цэцэрлэг, сургуулийн багш, удирдах ажилтан
- 6.3. Боловсрол, соёл, урлагийн газрын мэргэжилтэн
- 6.4. Төрийн болон төрийн бус байгууллага, эцэг, эх, иргэд, олон нийт

#### **ДОЛОО. ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА**

**Зорилт 3.1. Багш нарын мэргэжлийн чадамж, стандартад суурилсан тасралтгүй хөгжлийг дэмжих удирдлагын менежментийн чадавхыг бэхжүүлэх**

- 3.1.1. Багш, удирдах ажилтны мэргэжил ур чадвараа дээшлүүлэх хэрэгцээний болон "Ахиц амжилтын судалгаа"-д үндэслэн богино, дунд хугацааны сургалтын хөтөлбөр боловсруулан, хэрэгжүүлэх
- 3.1.2. Боловсролын удирдах ажилтны мэдлэг, ур чадвар, хандлага, сэтгэл ханамжийн судалгааг тогтмолжуулах
- 3.1.3. Багш нарын бие мэргэжлийн тасралтгүй хөгжлийг дэмжсэн аливаа бодлого, түүний хэрэгжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээнд оролцох оролцоог дэмжих
- 3.1.4. Багшийн гүйцэтгэлд суурилсан цалин хөлс, нэмэгдэл, урамшууллыг бодитоор тооцох аргачлалыг үр дүнтэй хэрэгжүүлэх нэгдсэн арга зүй, туршлагыг нэвтрүүлэх
- 3.1.5. Сургууль, цэцэрлэгт багш, удирдах ажилтны боловсролын магистр ба түүнээс дээш зэргийг нэмэгдүүлэх, мэргэжлийн тэргүүлэх, зөвлөх зэрэгтэй багш, удирдах ажилтны эзлэх хувийг үе шаттайгаар нэмэгдүүлэх
- 3.1.6. Багш, удирдах ажилтныг сонгон шалгаруулах нийтлэг журмыг мэргэжлийн стандартад нийцүүлэн боловсронгуй болгож, батлуулах, хэрэгжүүлэх

**Зорилт 3.2. Сургуулийн өмнөх болон бага, суурь, бүрэн дунд боловсролын чанарын үнэлгээнд суурилан багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийг мэргэжлийн ур чадвар, хандлагын судалгаанд үндэслэн хэрэгжүүлэх**

- 3.2.1. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгт ментор сургалтыг нэвтрүүлэх, ментор багшийг сонгож, чадавхыг тогтмол сайжруулах
- 3.2.2. Сургуулийн өмнөх насны хүүхдийн хөгжил, сургуульд бэлтгэсэн байдалд үнэлгээ хийж сургалтын үйл ажиллагааг чанаржуулах
- 3.2.3. Суралцагчдаас сургалтын хөтөлбөрийн дагуу "Ахиц, амжилтын судалгаа"-г үе шаттайгаар зохион байгуулж, үр дүнд суурилсан сургалтын хөтөлбөр, арга зүй, судалгаат хичээлийг тогтмол зохион байгуулах

- 3.2.4. Сургууль, цэцэрлэг бүрт хүүхдийн ахиц амжилт, багшийн арга зүй, туршлагыг дүгнэн, зөвлөгөө өгөх хяналт үнэлгээний дотоод багийг байгуулан ажиллах
- 3.2.5. Багшийн чадамж, ур чадвар, мэргэжлийн түвшинг үнэлэх олон хувилбарт уралдаан тэмцээнийг тогтмол зохион байгуулж, шагнаж урамшуулах
- 3.2.6. Төв суурин болон хөдөөгийн сумдын сургууль, цэцэрлэгийн багш нарыг харилцан суралцах боломжийг бүрдүүлж, "Багш солилцоо", "Судлаач багш", "Зочин багш" арга хэмжээг хэрэгжүүлэх

**Зорилт 3.3. Багшийн ажлын нөхцөл, тасралтгүй хөгжил, багш, ажилтны урамшуулал, нийгмийн баталгаа, сургалтын орчин, нөхцөлийг дэмжих**

- 3.3.1. Ур чадвар бүхий багш нарыг урих, багш, удирдах ажилтныг тогтвор суурьшилтай ажиллуулах, орон сууцны нөхцөл, нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх
- 3.3.2. "Багш хөгжлийн төв"-ийг стандарт шаардлагын дагуу тохижуулах
- 3.3.3. Багш удирдах ажилтны ажлын гүйцэтгэл, харилцаа, хандлага, сэтгэл ханамжийн судалгааг үндэслэн "Шилдэг багш", "Шилдэг удирдах ажилтан"-г шалгаруулах журам боловсруулж батлуулан, хэрэгжүүлэх
- 3.3.4. Боловсролын салбарт оролцогч төрийн болон төрийн бус байгууллага, эцэг, эх, олон нийтийн хамтын ажиллагаа, санаачилгыг нэмэгдүүлж, хамтран ажиллах, эцэг эхийн хурлыг сар бүр тогтмол хийж, сургууль, цэцэрлэгийн зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлэн, хамтын хариуцлагыг бэхжүүлэх

**Зорилт 3.4. Боловсролын салбарын цахим шилжилтийг нэмэгдүүлж, цахим платформыг хөгжүүлэх замаар сургалтын үйл ажиллагааг дэмжих**

- 3.4.1. Мэдээллийн технологийн хөгжилтэй уялдуулан цахим платформуудыг үе шаттайгаар нэвтрүүлэх, багш, удирдах ажилтнууд туршлага солилцон ур чадвараа хуваалцах мэдээллийн систем бий болгох, хамтдаа хөгжих боломжийг бүрдүүлэх.
- 3.4.2. Цахим хичээл, хэрэглэгдэхүүн бэлтгэх материаллаг болон интернетийн орчин нөхцөл бүхий "Цахим кабинет"-ыг байгуулах

**ДОЛОО. ХӨТӨЛБӨРИЙН САНХҮҮЖИЛТ**

- 7.1. Улсын төсөв.
- 7.2. Орон нутгийн төсөв.
- 7.3. Төсөл, хөтөлбөр.
- 7.4. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн хандив, тусламж
- 7.5. Бусад эх үүсвэр

**НАЙМ. ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

8.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллага, иргэд, олон нийтийн оролцоо уялдаа холбоог хангах, хөтөлбөрийн үе шат бүрийн төлөвлөлт, хэрэгжилтийн хяналт–шинжилгээ, үнэлгээ, санхүүжилтийн эх үүсвэр

шийдвэрлүүлэхийг аймгийн Засаг даргын тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс, Боловсрол, соёл урлагийн газар зохион байгуулна.

8.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үндсэн хэлбэр нь сургалт, хэлэлцүүлэг, туршлага судлах, хүүхэд нэг бүрийг хөгжүүлж буй тэргүүн туршлагыг түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагаа байх бөгөөд сургалтыг ажлын байрны, бүсчилсэн болон зайн сургалтын хэлбэрээр зохион байгуулна.

8.3. Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжих үйл ажиллагааны чиглэл, зохион байгуулах сургалт, сурталчилгааны ажлын агуулга, арга зүй, төлөвлөгөөг Боловсрол, соёл, урлагийн газар, иргэний нийгмийн байгууллагатай хамтран зохион байгуулна.

8.4. Орон нутгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг дарга, Засаг даргын Тамгын газар нь хөтөлбөрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэн, орон нутгийн онцлогт нийцүүлэн хэрэгжүүлэх, санхүүжүүлэх, зарцуулалтад хяналт тавих үүргийг хүлээнэ.

### **ЕС. ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖСЭНЭЭР ГАРАХ ҮР ДҮН**

9.1. Багш мэргэжлийн чадамж, стандартад суурилсан багшийн тасралтгүй хөгжлийн тогтолцоо бий болж багшийн онол, арга зүйн мэдлэг чадвар суурь түвшингээс ахисан байна.

9.2. Цахим орчин багшлахуй, суралцахуйг дэмжсэн платформ, цахим хичээл, цахим хэрэглэгдэхүүн бүхий сургалтын орчин бий болно.

9.3. Багшийн ажлын гүйцэтгэл, суралцагчдын сурлагын ахиц, амжилт, үр дүнд суурилсан сургуулийн менежмент, хөтөлбөрүүдтэй болно.

9.4. Багш, сурагчийн хөгжлийг дэмжсэн сургалт, хүмүүжил, нийгмийн эерэг орчин бүрдэнэ.

### **АРАВ. ХӨТӨЛБӨРИЙН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ**

10.1. Тус хөтөлбөрт заасан сургалтад хамрагдсан багш нар өөрийн болон сургалтын чанарын хөндлөнгийн үнэлгээг тогтмол хийх, үр дүнг ашиглана

10.2. Хөтөлбөрийн хэрэгжилтийг төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний хүрэх үр дүн болон шалгуур үзүүлэлтийн биелэлтээр гаргана.

10.3 Хөтөлбөрийн хэрэгжилтийг хангуулах ажлыг Боловсрол соёл урлагийн газар, сургууль, цэцэрлэг хариуцаж, аймаг, сумдын Засаг даргын тамгын газар хэрэгжилтэд байнгын хяналт тавьж ажиллана.

### **АРВАН НЭГ. ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ТУЛГАРЧ БОЛОХ ЭРСДЭЛ, ЭРСДЭЛИЙГ БУРУУЛАХ АРГА ЗАМ**

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараах эрсдэлтэй тулгарч болохыг анхаарч, тэдгээрийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга замыг тодорхойлох шаардлагатай. Үүнд:

11.1 Эдийн засгийн нөхцөл байдал хангалтгүй, тогтворгүй байхаас шалтгаалан боловсролын салбарт хийх төсвийн санхүүжилт хангалтгүй байх

11.2. Төрийн албаны тогтворгүй байдлаас шалтгаалан хэрэгжилтийг хангах багш, удирдах ажилтны ойлголт, хандлагын зөрүү гарч хэрэгжилт удаашрах

11.3. Нийгмийн онцгой нөхцөл байдал, байгалийн гамшиг, КОВИД-19 цар тахлын тархалтаас шалтгаалан хөл хорио тогтоох

Дээрх нөхцөл байдал хөтөлбөрийн хэрэгжилтийг удаашруулах эсвэл зогсоож, ач холбогдлыг бууруулах, хүссэн үр дүндээ хүрэхгүй байх эрсдэлийг бий болгоно. Үүнээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулахын тулд дараах арга хэмжээг авах шаардлагатай.



Д/д	Эрсдэл	Бууруулах арга хэмжээ
11.1	Эдийн засгийн нөхцөл байдал хангалтгүй, тогтворгүй байхаас шалтгаалан боловсролын салбарт хийх төсвийн санхүүжилт хангалтгүй байх	<ul style="list-style-type: none"> <li>o Хэрэгцээнд суурилсан санхүүжилтийн хатуу зарчмыг мөрдөх</li> <li>o Боловсролын салбарын хөрөнгө оруулагч Донор байгууллагуудад хандах, тэдний дэмжлэгийг татах</li> <li>o Хэрэгцээнд суурилсан хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг хэрэгжүүлэх</li> </ul>
11.2	Төрийн албаны тогтворгүй байдлаас шалтгаалан хэрэгжилтийг хангах багш, удирдах ажилтны ойлголт, хандлагын зөрүү гарч хэрэгжилт удаашрах	<ul style="list-style-type: none"> <li>o Бодлогын залгамж халааг алдагдуулахгүй байх арга хэмжээ авах</li> <li>o Хөтөлбөрийн хэрэгжилтийг мэргэжлийн байгууллага, алба нэгж, багш, удирдах ажилтнуудаар ахлуулах</li> <li>o ЗДТГ, БСУГ, Сургууль, Цэцэрлэг бүр жил бүрийн төлөвлөлтөд хөтөлбөрийн зорилтод үйл ажиллагааг тасралтгүй тусгах</li> </ul>
11.3	Нийгмийн онцгой нөхцөл байдал, байгалийн гамшиг, КОВИД-19 цар тахлын тархалтаас шалтгаалан хөл хорио тогтоох	<ul style="list-style-type: none"> <li>o Төлөвлөгөөнд үүсч болох нөхцөл байдлыг урьдчилан тооцож, бэлэн байдлын төлөвлөгөө боловсруулж ажиллах</li> <li>o Нээлттэй, онлайн сургалт, үйл ажиллагааны нөөц, эх үүсвэртэй болох</li> </ul>

"ШИНЭ БАГШ" ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ 2021-2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх үр дүн	Төсөв /Сая.төг/	Хугацаа /IV улирал/	Хариуцах нэгж
<b>Зорилт 3.1. Багш нарын мэргэжлийн чадамж, стандартад суурилсан тасралтгүй хөгжлийг дэмжих удирдлагын менежментийн чадварыг бэхжүүлэх</b>								
1	3.1.1. Багш, удирдах ажилтны мэргэжлийн үр чадвараа дээшлүүлэх хэрэгцээний болон "Ахиц амжилтын судалгаа"-д үндэслэн болно, дунд хугацааны сургалтын хөтөлбөр боловсруулан, хэрэгжүүлэх	"Мэдээлэл харилцааны технологи", "Хөгжлийн судалгаа", "Боловсролын менежмент", "Хувь хүний хөгжил" гэсэн 4 чиглэлээр сургалтын хөтөлбөр боловсруулах	Сургалтын хөтөлбөр боловсруулах үе шат	0	Хөтөлбөр боловсруулагдсан байна.	10.0 /Урс, ОНТ, бусад/	IV улирал	БСУГ
2	3.1.2. Боловсролын удирдах ажилтны мэдлэг, үр чадвар, хандлагын сэтгэл ханамжийн судалгааг тогтмолжуулах	"Сургуульд суурилсан менежментийн залвар"ыг Хангал суманд хэрэгжүүлэх "Удирдах ажилтны манлайлал" өдөрлөг зохион байгуулах	Хэрэгжүүлэх үе шат 2	0	Хангал суманд нөвтрүүлсэн байна. 2 удаа зохион байгуулагдсан байна	- 10.0 /Урс, ОНТ, бусад/	II-III улирал III, IV улирал	БСУГ, Хангал суман ЕБС БСУГ, СЗДТ
3	3.1.4. Багшийн гүйцэтгэлд суурилсан цалин өлс, нэмэгдэл, урамшууллын бодитор тооцох аргачлалыг үр дүнтэй хэрэгжүүлэх нэгдсэн арга зүй, туршлагыг нөвтрүүлэх 3.1.5. Сургууль, ижирхэт багш, удирдах ажилтны боловсролын зэргийг магистр ба түүнээс дээш , мэргэжлийн тэргүүлэх зөвлөх зэрэгтэй багш, удирдах ажилтны эзлэх хувийг үе шаттайгаар нэмэгдүүлэх	Сургалтын байгууллага бүр дээр багшийн ажилын "Гүйцэтгэлийн менежментийн баг"-ийг байгуулж, "Хөгжсөн багш" шалгаруулах журмын шаардлагаар боловсруулж, хэрэгжүүлэх Боловсролын салбарын удирдах ажилтныг үе шаттайгаар бэлтгэх	Багийн тоо- 20 Магистр зэрэгтэй удирдах ажилтны хувь	0 20	Гүйцэтгэлийн менежментийн 20 багтай болсон байна. Хөгжсөн багшийн шалгуур үзүүлэлтийг боловсруулсан байна. 45 хувьд хурган.	-	III улирал III-IV улирал	БСУГ, ЕБС БСУГ
<b>Зорилт 3.2. Сургуулийн өмнөх болон бага, суурь, бүрэн дунд боловсролын чанарын үнэлгээнд суурилсан багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийг мэргэжлийн үр чадвар, хандлагын судалгаанд үндэслэн хэрэгжүүлэх</b>								
1	3.2.1. Ерөнхий боловсролын сургууль ицэрлэгт ментор сургалтыг нөвтрүүлэх, багшийг чадваржуулах	Үндэсний хэмжээний үр чадвартай зөвлөх багшийг түшиц сургуульд ажиллуулах, зөвлөх үйлчилгээний багтай болж	Зөвлөх үйлчилгээний тоо-2, багийн тоо-1	0	Зөвлөх үйлчилгээ хийгдсэн байна	45.0 /БХС/	III-IV улирал	БСУГ, ЕБС
2	3.2.2. Сургуулийн өмнөх насны хүүхдийн хөгжил, сургуульд бэлтгэсэн байдалд үнэлгээ хийж сургалтын үйл ажиллагааг чанаржуулах	Сургуулийн өмнөх боловсролын түвшинд сургуульд бэлтгэсэн байдлыг үнэлэх журмыг хэрэгжүүлэх	Сургуульд бэлтгэгдсэн байдлын үнэлгээ хувь		78	-	III-IV улирал	БСУГ, СӨББ
3		Аймагын хэмжээнд сургуулийн өмнөх боловсрол олгох үлгэрчилсэн сургалтын хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх	Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь	0	80	-	III-IV улирал	БСУГ, СӨББ
4	3.2.3. Суралцагчаас сургалтын хөтөлбөрийн дагуу "Ахиц амжилтын судалгаа"-г үе шаттайгаар зохион байгуулж, үр дүнд суурилсан сургалтын хөтөлбөр, арга зүй, судалгааг хөгжлийн тогтмол зохион байгуулах	"Багшийн хөгжүүлэх сургалтын төлөвлөгөө"-г судалгаажуун бүрээр боловсруулах	Сургалтын төлөвлөгөөний тоо-10	0	ЗЕШ-ын 10 хичээлийн сургалтын төлөвлөгөөтэй болсон байна.	-	III-IV улирал	БСУГ

5	3.2.4. Сургууль, цэцэрлэг бүрт хүүхдийн ажил зохиолт, бэлтгэл арга зүй, туршлагыг дүннэн, зөвлөгөө өгөх хяналт үнэлгээний дотоод бэлтгэл байгуулсан ажиллах	Сургууль бүр хүүхдийн ажил зохиолтын судалгаа шалгалтаа хийж "Хяналт үнэлгээний дотоод баг"-ийг байгуулах	Хяналтын багийн тоо-42	0	Байгууллага бүр хяналтын үнэлгээний дотоод багтай болсон байна	-	IV улирал	ЕБС
6		Бэлтгэл хөндөгч залуучуудын манлайлал арга хэмжээг үе шатай зохион байгуулах	Клубын тоо-17	-	Сум бүрт 1 клуб байгуулагдсан байна.	-	IV улирал	БСУГ,ЕБС, СӨББ
7	3.2.5. Багийн чадамж, урчдаар, мэргэжлийн түвшинг үнэлэх олон хувилбар уралдаан тэмцээнийг тогтмол зохион байгуулж, шалгах урамшуулах	"Шинэ санаа-шилдэг бүтээл" арга хэмжээг үе шатай зохион байгуулах	Арга хэмжээний тоо-1, шилдэг бүтээлийн тоо 6	-	Шилдэг бүтээлийн сангай болсон байна.	-	III улирал	БСУГ, ССАЗА
8		"Судалсан бэлтгэл" эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах	Хурал -1	Улсад тусгай байр	Илтгэлийг шалгаруулж, улсад 1-3 байрт шалгарсан байна.	-	III-IV улирал	БСУГ,ЕБС, СӨББ
9	3.2.6. Төв суурин болон хөдөөгийн сумд сургууль, цэцэрлэгийн багш нарыг харилцан суралцах боломжийг бүрдүүлж, "Багш солилцоо", "Зочин багш" арга хэмжээг хэрэгжүүлж	Багш, удирдах ажилтны "Солилцоо" хөтөлбөрийг хэрэгжүүлж	Хөтөлбөр хэрэгжилтийн хувь	-	Хөтөлбөр хэрэгжиж 25 багш удирдах хамрагдсан байна.	-	IV улирал	БСУГ,ЕБС, СӨББ
10		Мэргэжил, арга зүйн зөвлөлийн гишүүдийг туршлага судлуулах	Туршлага судлах ажил-1	-	Дорнод аймагт туршлага судалсан байна.	7.0 /У/с, ОНТ, бусад/	III улирал	БСУГ, ЕБС,СӨББ
<b>Зорилт 3.3. Багийн ажлын нөхцөл, тасралтгүй хөгжил, багш, ажилтны урамшуулал, нийгмийн баталгаа, сургалтын орчин, нөхцөлийг дэмжих</b>								
1	3.3.1. Ур чадвар бүхий багш нарыг урих, багш, удирдах ажилтныг тогтвор суурьшилтай ажиллуулах, орон сууцны нөхцөл, нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлж	Суманд ажиллахаар ирсэн залуу багш нарын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, тогтвор суурьшилтай ажиллахад нь дэмжлэг үзүүлж	Багийн тоо-5	-	5 багшид дэмжлэг үзүүлсэн байна.	У/с, ОНТ, бусад/	IV улирал	СЗДТГ,ЕБС, СӨББ
		ур чадвартай, шилдэг залуу багшийг орон сууц худалдан авахад хөнгөлөлт, дэмжлэг үзүүлж	Багийн тоо-3	-	3	30.0 /БХЦ/	IV улирал	НБХ,БСУГ
2	3.3.2. "Багш хөгжлийн төв"-ийг стандарт шаардлагын дагуу тохиожуулах	Шилдэг үйл ажиллагаатай "Багийн хөгжлийн төв"-ийг шалгаруулах	Шилдэг БХТ-3	0	Шилдэг үйл ажиллагаатай "Багийн хөгжлийн төв"-3 шалгарсан байна.	3.0	IV улирал	БСУГ
3	3.3.3. Багш удирдах ажилтны ажлын гүйцэтгэл, харилцаа, хандлага, сэтгэл ханамжийн судалгаана үндэслэн "Шилдэг багш", "Шилдэг удирдах ажилтан", "Шилдэг үйлчилгээний ажилтан"-г шалгаруулах журам боловсруулж батлуулах, хэрэгжүүлж	Боловсролын салбарын шилдэг багш, ажилтан шалгаруулах арга хэмжээг "Засаг даргын нэрэмжит" болгон зохион байгуулах	арга хэмжээний тоо-1, шилдэг багийн тоо 3	-	"Аймгийн Засаг даргын нэрэмжит" арга хэмжээг зохион байгуулж, шилдгүүдээ шалгаруулсан байна.	3.0 /У/с, ОНТ, бусад/	IV улирал	АЗДТГ,БСУГ
4		"Хөгжсөн багш", ажилтныг урамшуулах ажил зохион байгуулах	Урамшуулах багш, ажилтны тоо-25	0	Журмын дагуу мэргэжил бүрээр багш, ажилтныг шалгаруулсан байна.	12.5 /У/с, ОНТ, бусад/	IV улирал	БСУГ
<b>3.4. Боловсролын салбарын цахим шилжилтийг нэмэгдүүлж, цахим платформ хөгжүүлэх замаар сургалтын үйл ажиллагааг дэмжих</b>								

1	3.4.1. Мэдээллийн технологийн хөгжилтэ үйлдүүлэн цахим платформуудыг үе шаттайгаар нэвтрүүлж, багш, үйлэрэн ажилтнууд туршлага солилцон ур чадвараа хуваалцах мэдээллийн систем бий болгох, хамтдаа хөгжих боломжийг бүрдүүлэх.	ЕБС-ийд цахим сүлжээнд бүрэн холбох	Цахим сүлжээнд холбогдсон сургуулийн тоо-5	0	5 сургууль цахим сүлжээнд холбогдсон байна	15 /Улс, ОНТ, бусад/	IV улирал	СЭДТГ,ЕБС, СӨББ
2	3.4.2. Цахим хичээл, хэрэглэгдхүүн бэлтгэл материаллаг болон интернетийн орчин нөхцөл бүхий "Цахим кабинет"-ыг байгуулах	Шилдэг үйл ажиллагаатай "Цахим сургууль" шалгаруулах удирдамж боловсруулж, хэрэгжүүлэх	Цахим сургуулийн тоо-5	0.0	5 цахим сургуультай болсон байна	2.5 /Улс, ОНТ, бусад/	IV улирал	БСУГ
<b>НИИТ</b>						143		
<b>ОНТ</b>						68.0		
<b>БХС</b>						75		